



**АРДЧИЛСАН НАМЫН  
ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЖАРГАЛТХААН СУМЫН ХОРООНЫ  
2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020 ОН

**ЗОРИЛГО:** Өрх гэрийн хөгжлийг эрхэмлэж, ажилтай орлоготой, эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, эрх чөлөөт иргэнээ эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах боломж, нөхцлийг бүрдүүлэх, байгаль орчинд ээлтэй, ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн бодлого зорилтыг хэрэгжүүлнэ.

**Уриа: ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРТ**

**Зорилт-1 ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ / Боловсрол, Эрүүл мэндийн үйлчилгээ, Цахим засаглал, Өрх, гэр бүл, Хүүхэд, Нийгмийн хамгаалал, Аялал жуулчлал, Спорт, Урлаг \ ХӨГЖЛИЙГ ХҮРТЭХ ЖАРГАЛТХААНЧУУД/ ХӨГЖЛИЙГ ХҮН БҮРТ**

- 1.1. Аймгийн "Оюунлаг Хэнтийчүүд" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Оюунлаг Жаргалтхаанчууд" дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.2. "Зөв Монгол хүүхэд" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3. Спорт заал бүхий 320 хүүхдийн сургуулийн байрыг шинээр барьж, ашиглалтанд оруулна.
- 1.4. Цахим Жаргалтхаан хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.5. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, эмч нарыг мэргэжил олгох, мэргэшүүлэх сургалтанд хамруулах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулна.
- 1.6. Сумын эрүүл мэндийн төвийн барилгад их засвар, өргөтгөл хийнэ.
- 1.7. Гэр бүлийн гишүүн бүрт ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээх хөгжүүлэх, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.
- 1.8. Сумын иргэдийг зээлийн хөнгөлттэй нөхцлөөр хувийн орон сууцтай болгох хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.9. Хүүхэд хамгааллыг сайжруулах, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, өрх, гэр бүлийн хөгжлийг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ.
- 1.10. Архигүй Жаргалтхаанчууд дэд хөтөлбөр, Эерэг Жаргалтхаан хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.11. Иргэдэд чиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх гэрийн амьжиргааг дэмжих бодлогыг хэрэгжүүлж ажиллана.
- 1.12. Соёл урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.13. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, Монгол үндэсний спорт, уламжлалт тоглоом наадгайг сэргээн хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.
- 1.14. Аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаад дотоодын жуулчдыг татах, орон нутаг, өв соёлоо сурталчлах зорилгоор Эвент арга хэмжээг жил бүр зохион байгуулна.



**ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ / Жижиг дунд бизнес, Үйлдвэрлэл, үйлчилгээ, Ажлын байр, Аж үйлдвэр, Дэд бүтэц, Эрчим хүч, Барилгын салбар, Шинжлэх ухаан технологи, Аялал жуулчлал/**

- 2.1. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийн санг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулж, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 2.2. "Ажлын байр- Жаргалтхааны хөгжил" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.
- 2.3. Сумын төвд авто зам шинээр тавина.
- 2.4. Төвлөрсөн шугам сүлжээнд айл өрх, аж ахуйн нэгжүүдийг холбох ажлыг үе шаттайгаар хийж хэрэгжүүлнэ.
- 2.5. Суманд өрхийн тариалалт, төмс хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэлийг дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлж, хүлэмж, агуулах, зоорийг шинээр барьж байгуулна.
- 2.6. Нийтийн ариун цэврийн байгууламж шинээр байгуулна.
- 2.7. Засаг даргын Тамгын газрын барилгыг шинээр барьж, ашиглалтанд оруулна.

**Гурав. ЭЗЭН МОНГОЛ / Орон нутгийн хөгжил, эрүүл, аюулгүй орчин, Шинэ сум, Бэлчээр, Мал аж ахуй, Газар тариалан, хүнсний аюулгүй байдал / НУТАГТАА ЭЗЭН ЖАРГАЛТХААНЧУУД**

- 3.1. Хашаандаа сайхан амьдарья", "Жорлонгоо өөрчилье" төслүүдийг хэрэгжүүлнэ.
- 3.2. Иргэдийн оролцоотой "Шинэ сум" хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлнэ.
- 3.3. Бэлчээрийн менежментийг сайжруулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 3.4. "Чинээлэг малчин" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.5. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүд болон үйлчилгээний газрууд байгуулахыг дэмжиж ажиллана.
- 3.6. Ур тариа, малын тэжээл тариалах, тэжээлийн үйлдвэр байгуулахыг дэмжиж ажиллана.
- 3.7. Цахилгаан, дэд бүтцийг шийдсэн "Малчдын хороолол"-ыг байгуулах
- 3.8. Малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор цөм сүрэг бий болгох, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлнэ.
- 3.9. Шинэ залуу малчин өрхийг дэмжин "Малжуулах" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.10. Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.
- 3.11. Мах махан бүтээгдэхүүн, сүү цагаан идээг зах зээлд нэвтрүүлэх хяналтын горимыг сайжруулан малыг эрүүлжүүлэх ухаалаг хяналтын системийг нэвтрүүлнэ.

317144297  
0046 907408

**Дөрөв: ХУУЛЬТАЙ МОНГОЛ/ төрийн алба, эрх зүйн боловсрол, хүний эрх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах, батлан хамгаалах / хуулийг дээдлэгч ЖАРГАЛТХААНЧУУД**



- 4.1. Төрийн албан хаагчдыг чадавхижуулах, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг сайжруулах, төрийн албан хаагчдын хариуцлагыг дээшлүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.2. Иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх Бүх нийтийн эрх зүйн боловсрол үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 4.3. Авила, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, нийтийн албаны үйл ажиллагааг иргэдэд ил тод, ялгамжгүй, шударга, хүртээмжтэй хүнд сурталгүй хүргэнэ.
- 4.4. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам, хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлж, аюулгүй амар тайван амьдрах баталгааг хангахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.
- 4.5. Орон нутгийн гамшигаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлж, гамшигийн эрсдлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

**Тав: АЮУЛГҮЙ, АМГАЛАН МОНГОЛ / Байгаль орчин, ногоон байгууламж, хог хаягдлын менежмент , ногоон хөгжил, гадаад харилцаа /**

- 5.1. Эко Жаргалтхаан хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 5.2. Ойжуулах, ойг цэвэрлэх, нөхөн сэргээх асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, шинэ технологи нэвтрүүлнэ.
- 5.3. Сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, мод үржүүлгийн газар шинээр байгуулна.
- 5.4. Сумын хэмжээнд байгаа гол, булаг, шанд, нуур, цөөрмийг хамгаалалтад авч байгалийн тэнцвэрт байдлыг хангана.
- 5.5. Ус, хөрс, бэлчээрийг хамгаалах, цөлжилттэй тэмцэх бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ
- 5.6. Цэвэр тохилог Жаргалтхаан хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 5.7. Гадаад харилцааг өргөжүүлж, гадаад орны төрийн болон төрийн бус байгууллагуудтай холбоо тогтоож, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

**АРДЧИЛСАН НАМЫН ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН ХОРООНЫ  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

